



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар A/124

Улаанбаатар хот

Г Авлигын эсрэг үйл ажиллагааны
төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны 2023 оны "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, биелэлтэд хяналт тавьж, тайланг 2023 оны 6 дугаар сарын 15-ний өдөр болон 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Авлигатай тэмцэх газар хүргүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газарт үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.БАТТУЛГА

142310323

Биеийн тамир, спортын улсын хорооны
даргын 2023 оны 04 дугаар сарын 25.-
ний өдрийн 7.12 дугаар тушаалын
хавсралт

**БИЕИЙН ТАМИР СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ 2023 ОНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн үзүүлэлт
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хүрээнд Олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд	1.1 АТГ-аас бэлтгэсэн тв шторк, нийтлэл зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байгууллагын цахим хуудас болон нийгмийн сүлжээнд байршуулах, нийтэд хүргэх	-Баримтжуулах, -үр дүнг тооцсон байх, -харьяа нэгжүүдийг хамруулсан байх
		1.2 Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг салбар нэгж, байгууллагын онцлогт тохируулан зохион байгуулах	Өдөрлөг нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан байх, үр дүнг тооцох
		1.3 Өөрсдийн үйл ажиллагааг авлигаас ангид байхад чиглэсэн ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий сурталчилгааг олон нийтэд хүргэсэн байх	Сурталчилгааны материал боловсруулах, Байгууллагын албан ёсны веб хуудсан байршуулах, сурталчилгааны самбарт байршуулах
2	Хөрөнгө орлогын мэдүүлэгийн бүрдүүлэлтийн цахим хуудсын хэрэгжилтийг хангах	2.1 Албан хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан авах, цахим бүрдүүлэлтийг хангаж ажиллах	Хуулийн хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан авсан байх
		2.2 Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн ХАСУМ-г Авлигатай тэмцэх газарт хянуулан дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилох	АТГ-н дүгнэлтийг үндэслэн ажилд томилсон байх
3	Байгууллагын удирдлагын авилгатай тэмцэх хүсэл, эрмэлзэл, санаачлага өрнүүлэх	3.1 Удирдлага салбар нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн тайлагнах	Олон нийт танилцах боломжоор хангах

		3.2 Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, алба хаагчийн ёс зүйг дээшлүүлэх, нөлөөллийн ажил зохион байгуулах	- Ёс зүйн дүрэмд Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгасан байх - Албан хаагчийн сахилга, ёс зүйн өргөдөл, гомдлыг шалган шийдвэрлэх
4	Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох	4.1 Байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах асуудлыг олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжоор хангах	Байгууллагын албан ёсны хуудсанд нээлттэй ил тод байх
		4.2 Байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байх	Үйл ажиллагааны тайланг нийтэд ил тод байршуулах
5	Авлигын эсрэг хууль тогтоомж болон бусад холбогдох хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах	-Авлигын эсрэг хууль -Шилэн дансны тухай хууль -Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль зэрэг бусад холбогдох хууль тогтоомжийг цахим хуудсанд байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах	Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэх

--Оо--